

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 15

№06

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн танхимд (I-203) 10:00 цагаас 86.9 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд: Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Аюурзана, Б.Оюунтунгалаг, Д.Биндиряа, Л.Амартүвшин, Б.Батдэмбэрэл, Б.Мөнхцэнгэл, А.Болормаа, Я.Батцэцэг, Ш.Цоож, М.Дэлгэрмаа, Р.Мядагмаа, Ц.Энхтуул, Г.Батцэцэг, Ч.Улам-Оргил, Г.Ариунтөгс нар оролцов.

Хэлэлцсэн асуудал:

1. ШУТИС-ийн бакалаврын цөм хөтөлбөрт тавигдах шаардлага
 - СЦШГ-ын захирал Н.Эрдэнэхүү
2. Шинээр болон шинэчлэн боловсруулах сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх ажлын хуваарь
 - СЦШГ-ын захирал Н.Эрдэнэхүү
3. Ахисан түвшний хөтөлбөрийн шинжлэх ухааны суурь хичээлийн санал
 - АТХА-ны дарга Д.Оюунцэцэг

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

| № | Хэлэлцүүлсэн асуудал | Санал, зөвлөмж | ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: |
|----|---|--|---|
| 1. | ШУТИС-ийн цөм хөтөлбөрт тавигдах шаардлага | <p>Англи хэлний хичээлийг 5 багц цагаас доошгүй байхаар төлөвлөх;</p> <p>Менежментийн чиглэлийн хөтөлбөрт бизнес менежментийн англи хэлийг оруулах;</p> <p>Аялал жуулчлал хөтөлбөрийг бизнесийн удирдлага, менежмент, нийгмийн шинжлэх ухаан (M2) ангилалд оруулах;</p> <p>Математикийн хичээл дээр 3 ангилал үүсгэсэн боловч нарийвчилсан агуулгын өөрчлөлт гаргах;</p> <p>Математикийн хичээлийн ангилалыг А, В, С үсгээр ялгаж тодорхойлох;</p> <p>Шаардлагад механик чиглэлийн хичээлийг оруулж өгөх;</p> <p>Төгсөгчийн 11 хэв шинжтэй уялдуулан инженерийн ёс зүй хичээлийг заавал судлахаар тусгах;</p> <p>Төслийн хичээлийг цаг тооцох журамтай уялдуулан шийдвэрлэх;</p> | <p>“ШУТИС-ийн бакалаврын цөм хөтөлбөрт тавигдах шаардлага”-д хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн санал, зөвлөмжийг тусган хэрэгжүүлэхийг (100%) дэмжлээ.</p> |
| 2. | Шинээр болон шинэчлэн боловсруулах сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх ажлын хуваарь | <p>Хөтөлбөрийн ерөнхий хорооны томилогдсон гишүүн багийг ахлах бөгөөд сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад үнэлгээ хийх, зөвлөн туслах ажлын хуваарь гаргаж багийн гишүүдийн жигд оролцоотойгоор ажиллах;</p> <p>Сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад үнэлгээ хийхдээ Сургалтын бодлого хөтөлбөрийн албанаас гаргасан хөтөлбөрийн үнэлгээ хуудсыг ашиглах ба тухайн хөтөлбөрийн аль чиглэлд сайжруулалт хийхийг тодорхойлж, тухай бүрд зөвлөгөө өгч ажиллах;</p> | <p>Удирдамжийн дагуу томилогдсон баг бакалаврын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлын явцад үнэлгээ хийх, зөвлөн туслах үйл ажиллагааг 5 сарын 29-өөс 2023 оны 6 дугаар сарын 06 хооронд зохион байгуулна.</p> <p>Хөтөлбөрийн ерөнхий хороо нь VI/9-VI/13-ны өдрүүдэд хуралдан шинэчлэн</p> |

| | | | |
|----|---|---|---|
| | | Бүрэлдэхүүн болон харьяа сургуулийн хөтөлбөрийн дэд хороо өөрийн хариуцан хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрийн төслийг хэлэлцэж, хөтөлбөрийн ерөнхий хороонд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах; | боловсруулсан бакалаврын хөтөлбөрүүдийг хэлэлцүүлнэ. |
| 3. | Ахисан түвшний хөтөлбөрийн шинжлэх ухааны суурь хичээлийн санал | <p>Судалгааны семинарыг яаж тусгахыг тодорхой болгох;</p> <p>Багц цагийг 2-р хязгаарлаж байгааг анхаарах, гадаадын их дээд сургуульд дүйцүүлэхэд хүндрэл гардаг. Тиймээс 3 кредитээр төлөвлөх;</p> <p>Мэргэжлийн магистр минимум багц цаг 32-р тооцсон байна. Олон улсад 35-с доошгүй байдаг. Шилжилтийн үе гэдгээр 32-36 гэж хязгаар зааж өгөх;</p> <p>Судалгааны чиглэлээс хамаарсан олон хичээлийг нээлттэй хэлбэрээр тавих;</p> | Ахисан түвшний хөтөлбөрт шинжлэх ухааны суурь хичээлийг төлөвлөхдөө ХЕХ-ны гишүүдийн санал, зөвлөмжийн тусган, дахин сайжруулж, хөтөлбөртөө тусган ажиллах. |

Танилцсан:



Н.Эрдэнэхүү
/ХЕХ-ны дарга/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



М.Эрдэнэтуяа
/ХЕХ-ны нарийн бичгийн дарга/